

Монгол улс дахь цэцэрлэгийн хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлага, өнөөгийн байдал

Д.Батсайхан^{*а}, Ц.Эрдэнэтуяа^а

^аМонгол Улсын Боловсролын Их Сургуулийн
Сургуулийн өмнөх боловсролын сургууль, Урлагийн тэнхим

Хураангуй

Өгүүлэлд Монгол улсад цэцэрлэгийн хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлага, ажиллаж буй багш нарын эзэмшсэн мэргэжлийн чиглэл, ур чадвар, тулгамдаж буй зарим асуудлын талаар өгүүлнэ.

2018-2019 оны БСШУСЯ-ны СӨБ-ийн статистик мэдээнд нийт 1435 цэцэрлэгт 663 хөгжмийн багштай гэсэн тоон үзүүлэлт гарсан. Улсын хэмжээнд нийт цэцэрлэгийн 50 гаруй хувьд нь мэргэжлийн хөгжмийн багш дутагдалтай төдийгүй ажиллаж буй багш нар нь мэргэжлийн бус байгаа нь анхаарал татсан асуудлын нэг юм. Энэ тоон үзүүлэлтээс харахад онол арга зүйн үндэслэлтэй хөгжмийн сургалт, үйл ажиллагааг зохион явуулж байгаа эсэх нь эргэлзээтэй байна. Үүнээс үүдэн хөгжмийн багш нарыг бэлтгэдэг их дээд сургууль, коллежийн сургалт, төгсөлт, хөгжмийн багш нарын хүрэлцээ, багшаар ажиллахгүй байгаа шалтгаан, ажиллаж байгаа багш нарын эзэмшсэн мэргэжлийн чиглэл, ажиллах нөхцөл, нийгмийн асуудлууд ямар байдалтай байгаа зэрэг асуудлууд урган гарч ирнэ.

Хөгжмийн багш нарын хүрэлцээ дутагдалтай, мэргэжлийн ур чадвар харилцан адилгүй байгаа нь статистик мэдээгээр харагдаж байна. Иймээс асуудлыг шийдэх арга зам, хөгжмийн багшийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх боломж гарцыг хайх шаардлага тулгараад байна. Хөгжмийн багшийн хүрэлцээг нэмэгдүүлэх, асуудлыг шийдвэрлэх арга зам, санал зэргийг өгүүлэлд тусгасан болно.

Түлхүүр үг

Цэцэрлэгийн хөгжмийн багш, багшийн ур чадвар, хөгжмийн багш бэлтгэх сургалт, бага насны хүүхдийн хөгжмийн боловсрол.

Удиртгал

Хүүхдийг урлагаар дамжуулан хөгжүүлэхэд хөгжмийн багшийн оролцоо онцгой үүрэгтэй. Сургуулийн өмнөх нас нь хүүхдийн хамгийн эмзэг мэдрэмтгий, эрчтэй хөгжлийн үе шат юм. Энэ насанд хүүхдийн хөгжмийг ойлгож мэдрэх, гоо сайхныг таашаах, хөгжмийн соёлын суурь тавигдах, авьяас чадвар хөгжих хамгийн тааламжтай үе юм. Хөгжим нь хүүхдийн хөгжил, төлөвшилд дуу, хөгжим, бүжгээр дамжуулан тэдний төсөөлөл, дүрслэл, уран сэтгэмж, гоо сайхны таашаал авах мэдрэмжийг хөгжүүлэхээс гадна хөгжмийн хэл, хөгжмийн шинж төрх, уран сайхны дүр, дүрслэлийг ашиглан хүүхдийн дотоод ертөнцийг нээн илрүүлэх, сэтгэл санааг сэргээн баясгах онцгой чухал үүрэг, ач холбогдолтой юм. Тиймээс сургалт үйл ажиллагааг мэргэжлийн хөгжмийн сургалт онол, арга зүйд суурилан, хүүхэд бүрийн нас, хувийн онцлогийг харгалзан зохион байгуулах шаардлагатай.

Судалгааны ажлын зорилтын хүрээнд цэцэрлэгт ажиллаж байгаа хөгжмийн багш нарын эзэмшсэн мэргэжил, төгссөн сургууль, ажлын туршлага, мэргэжлийн бус багш нарын мэргэжил дээшлүүлэх боломжийг эрэлхийлсэн.

Цэцэрлэгийн хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлага, тулгамдсан асуудлын тухай сургалт семинар, уулзалтын үед СӨБ-ын удирдлагууд онцгойлон хөндөж ярьдаг. 2016 онд МУБИС-иас зохиогдсон “Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал шийдэл” эрдэм шинжилгээний хуралд хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлага, хөгжмийн багш бэлтгэх тухай асуудлыг дэвшүүлэн илтгэл хэлэлцүүлж байсан (Ариунзул, Эрдэнэжаргал, 2016, х.350). Хэдий хөгжмийн багш хөтөлбөрөөр суралцагчдыг бэлтгэж эхэлсэн ч хөгжмийн багшаар ажиллаж байгаа багш нарын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, нийгмийн шийдэгдээгүй олон асуудлууд, энэ чиглэлээр судалгаа шинжилгээний ажил хомс хэвээр байна.

Монгол улсын хэмжээнд цэцэрлэгийн хөгжмийн багшийн хүрэлцээ дутмаг, мэргэжлийн бус хүмүүс ажиллаж байгаа нь хэд хэдэн шалтгаантай хэмээн таамаглаж байна:

- хөгжмийн багш мэргэжлээр суралцан төгссөн их дээд сургуулийн төгсөгчид цэцэрлэгийн хөгжмийн багшаар ажиллах сонирхол бага, ажлын ачаалал их, цалин бага, илүү цагийн хөлс авдаггүй;

^{*}Холбоо барих зохиогч: batsaikhan@msue.edu.mn

- хөгжмийн бусад чиглэлийн мэргэжил эзэмшсэн хэдий ч цэцэрлэгийн хөгжмийн багшийн орон тоонд ажилладаг;
- хөгжмийн багшийн мэргэжил эзэмшээгүй ч авьяастай багш суурьтай, багш бус өөр мэргэжлийн, ямар нэг боловсролын зэрэггүй хүмүүс цэцэрлэгийн багшаар ажиллахыг хүлээн зөвшөөрдөг (багшийн хүрэлцээ бага учраас);
- өөр мэргэжил эзэмшсэн зарим хөгжмийн багш нар санхүүгийн боломж, цэцэрлэгийн хөгжмийн багш бэлтгэх сургалтын хугацаа урт зэрэг асуудлаас хамааран мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдах нь бага г.м.

Цэцэрлэгийн хөгжмийн багшаар ажиллах хүний нөөцийн хүрэлцээ бага, мэргэжлийн бус багш нар ажиллаж байгаа нь хүүхдийн хөгжил төлөвшилд онцгой ач холбогдолтой хөгжмийн сургалтыг чанартай, үрдүнтэй зохион байгуулахад сөргөөр нөлөөлж байна. Иймээс тухайн асуудлыг шат дараалалтайгаар шийдвэрлэх нь зүйтэй. Нэн түрүүнд хөгжмийн багш нарын нарийвчилсан судалгааг гарган, цаашид ямар чиглэлээр хэрхэн багшийн хүрэлцээг нэмэгдүүлэх, ур чадварыг дээшлүүлэх, сургалтад хамруулах боломжийг судлан тогтоох, нийгмийн асуудал, ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зэргийг дурдаж болно. Монгол улс дахь цэцэрлэгийн хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох.

Хөгжмийн багшийн мэргэжлээр төгссөн багш нараас гадна хөгжмийн суурь мэргэжилтэй, багш суурьтай, өөр мэргэжлээр төгссөн болон бүрэн дунд ЕБС төгсөөд хөгжмийн багшийн орон тоонд ажиллах тохиолдол ажиглагдсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын удирдлагын зүгээс хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлага их байгааг анхааран хөгжмийн багш бэлтгэх саналыг олон удаа дэвшүүлж байсан. Цэцэрлэгийн хөгжмийн багшийн хүрэлцээ бага, мэргэжлийн хүний нөөц дутмаг байгааг харгалзан нийгмийн хариуцлагын үүднээс МУБИС-ийн Сургуулийн өмнөх боловсролын сургууль тухайн мэргэжлийн хөтөлбөрийг боловсруулан 2018-2019 оны хичээлийн жилээс “Багш, урлагийн боловсрол” хөтөлбөрөөр цэцэрлэгийн хөгжмийн багшийн өдрийн ангийг нээн сургалт үйл ажиллагааг зохион байгуулж эхлээд байна. Энэ нь хөгжмийн багшийн хүрэлцээг нэмэгдүүлэх чухал алхам болсон. Мөн мэргэжлийн бус хөгжмийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх хөрвөх сургалтыг зохион байгуулах боломж бий болсон. Тус цэцэрлэгийн хөгжмийн багшийн хөрвөх сургалтад хамрагдах багш нь бакалаврын зэрэгтэй тохиолдолд суралцах боломжтой.

Сургалтыг зохион байгуулах, нөхцөл байдлын судалгаа хийх явцад хэд хэдэн асуудал

тулгарсан. Иймээс дараах асуудлуудыг шийдэх шаардлагатай байна. Үүнд:

- хөрвөх ангийн сургалтын төлөвлөгөөг олон хувилбараар хийх (цэцэрлэгийн багш суурьтай бакалаврын зэрэгтэй; хөгжмийн суурьтай бакалаврын зэрэгтэй; багш суурьгүй; хөгжим суурьгүй өөр мэргэжлийн бакалаврын зэрэгтэй г.м.);
- ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулагдах хөгжмийн хичээлийн өртөг, зардлын асуудлыг МУБИС-ийн багшийн цаг тооцох журамд тодорхой тусгах;
- элсэгчдийн хөгжмийн боловсролын түвшин харилцан адилгүй байдлыг харгалзан сургалтын агуулгыг төлөвлөн боловсруулах;
- сургалтын материаллаг орчныг бэхжүүлэх г.м.

Багш суурьгүй, хөгжим суурьгүй бакалаврын зэрэгтэй өөр мэргэжлийн багшаар ажиллаж байгаа багш нарын бакалаврын хөрвөх эчнээ ангийн төлөвлөлтийг асуудлыг шийдэх ихээхэн хүндрэл бэрхшээлийг дагуулж байна. Суралцагчдын хувьд богино хугацаанд бага төлбөрөөр хөгжмийн багш болох сонирхол их байна. Нөгөө талаас ур чадвартай хөгжмийн багшийг бэлтгэхэд элсэгч, төгсөгчид тавигдах шаардлагыг хангаж чадахгүй байгаа асуудал нь зөрчлийг бий болгож байна. Мөн цэцэрлэгийн хөгжмийн багшийн хүрэлцээ бага байгаа нь ажлын ачаалал их, дугуйлан хичээлээс гадуурх үйл ажиллагааны илүү цагийг тооцдоггүй, бүлгийн тооноос үл хамааран цэцэрлэгийн хөгжмийн багшийн цалин ижил байгаа, ямар нэг нэмэгдэл байхгүй зэрэг асуудлаас хамаарч байна.

Монгол улсад хөгжмийн багш бэлтгэх сургуулиуд цаг үеийн байдал, боловсролын яамны бодлого, төлөвлөлтөөс хамааран хэд хэд удаа өөрчлөгдсөн (Пүрэвсүрэн, 2007, х.117). ЕБС, СӨББ, соёлын төвийн багш, мэргэжлийн хөгжмийн багш нарыг (Цогтгэрэл & Баттоогоо, 2013, х.13) Багшийн сургуулийн хөгжмийн анги (1965-1995; 2015-), Соёл гэгээрлийн дунд сургууль, СУИС болон бусад их дээд сургууль, коллеж, дунд сургуулиудад бэлтгэж ирсэн.

Үүнээс цэцэрлэгийн хөгжмийн багш нарыг тусгайлан Цэцэрлэгийн багш нарыг бэлтгэх сургуулийн хөгжмийн анги (1987-1992) (Эрдэнэчимэг, 2012, х.23), хөгжмийн багшийн коллеж (1992-1995), сурган хүмүүжүүлэх ухааны коллеж (1995-1998), Соёлын дээд сургууль (1998-2014) зэрэг сургуулиудад бэлдэж байв. СУИС-д (2014-одоог хүртэл) ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт ажиллах хөгжмийн багшийг хавсарсан байдлаар бэлтгэж байгаа ч ихэнх төгсөгчид нь ЕБС-д ажиллаж байгаа нь ажиглагдсан.

Судалгааны арга зүй

Судалгааг БСШУСЯ-ны статистик мэдээ, аймаг орон нутгийн боловсрол соёлын газрын мэргэжилтнүүдээс авсан асуулгын дүн, хөгжмийн багшийг бэлтгэж ирсэн их дээд сургуулийн түүхэн мэдээлэл зэргийг үндэслэн хийсэн. Судалгааны ажилд харьцуулалт, дүн шинжилгээ хийх, асуумж, түүврийн аргыг ашигласан.

БСШУСЯ-ны 2014-2019 оны хоорондох сургуулийн өмнөх боловсролын байгууллагын статистик мэдээнд тулгуурлан цэцэрлэгийн тоо, ажиллаж буй 21 аймаг орон нутгийн 663 хөгжмийн багшийн мэдээллийг гарган харьцуулсан. 15 аймаг орон нутгийн мэргэжилтнүүдээс багш нарын эзэмшсэн мэргэжил, төгссөн сургууль,

мэргэжлийн зэрэг, ажилласан жил, нас хүйс зэрэг тодорхой асуумжийн дагуу мэдээллийг цуглуулан дүн шинжилгээ хийн үр дүнг гаргасан.

Судалгааны үр дүн

БСШУСЯ-ны статистик мэдээнд сүүлийн таван жилийн хугацаанд улсын хэмжээний нийт цэцэрлэгийн тоо, хөгжмийн багш нарын тоог харьцуулсан байдлаас харахад (Сургуулийн өмнөх боловсролын 2018-2019 статистик мэдээ, 2019) 50-аас илүү хувьд нь цэцэрлэгийн хөгжмийн багш дутагдалтай байгаа нь тодорхой харагдаж байна (хүснэгт 1).

Хүснэгт 1

2014-2019 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн тоо, хөгжмийн багшийн харьцуулсан үзүүлэлт

Хичээлийн жил	Цэцэрлэгийн тоо	Дуу хөгжмийн багшийн тоо
2014-2015	1,177	568
2015-2016	1,288	639
2016-2017	1,354	657
2017-2018	1,416	741
2018-2019	1,435	663

Монгол улсын Шинжлэх ухаан, боловсролын сайд, Сангийн сайдын 1995 оны 227, 199 дүгээр хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралтад Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив тогтоох тухай тушаалд Дуу хөгжмийн багш “Бие даасан 4-өөс дээш бүлэгтэй цэцэрлэгт 1 байна” гэж тусгагдсан нь аймаг орон нутаг, баг, сумын дөрвөөс бага бүлэгтэй зарим цэцэрлэгт хөгжмийн багшаар ажиллах нөхцөлийг хаасан байх магадлалтай (Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив, 1995). Тухайн тушаал БСШУСЯ, СС-ын 2018 оны А/817/287-р тушаалаар хүчингүй болсон ч хөгжмийн багшийн орон тоонд 2017-

2018 оны хичээлийн жилд 741 багш, 2018-2019 оны хичээлийн жилд 663 багш болж 78-аар буурсны шалтгаан тодорхойгүй байна.

Улсын хэмжээнд шаардлагатай 50 орчим хувийг эзэлж буй хөгжмийн багш нарын хүрэлцээ нь аймаг орон нутаг, нийслэлийн хувьд харилцан адилгүй байгаа ажиглагдсан (хүснэгт 2). Цэцэрлэгийн тоо, хөгжмийн багшийн харьцуулсан үзүүлэлтээс ажиглахад хөгжмийн багшийн эзлэх хувь 14-76%-ийн хооронд хэлбэлзэж байна. Үүнээс: Төв (14%), Говьсүмбэр (18%), Говь-Алтай (20%), Нийслэлд (37%) бага; Орхон (67%), Дорноговь (69%), Сэлэнгэ (76%) аймгуудад хөгжмийн багшийн эзлэх хувь харьцангуй илүү байна (диаграмм 1).

Хүснэгт 2

Аймаг орон нутгийн цэцэрлэг болон хөгжмийн багшийн тоо

№	Аймаг нийслэл	Цэцэрлэг				Дуу хөгжмийн багш	
		Бүгд	Байршлаар			Бүгд	Эм
			Аймгийн төв	Сумын төв	Багийн төв		
Бүгд		1.435	1.016	385	34	663	524
1	Архангай	35	15	18	2	24	21
2	Баян-Өлгий	44	25	14	5	27	24

3	Баянхонгор	42	21	19	2	24	19
4	Булган	22	6	15	1	12	6
5	Говь-Алтай	29	10	17	2	6	5
6	Дорноговь	33	11	21	1	23	17
7	Дорнод	37	24	13	-	24	14
8	Дундговь	21	7	14	-	11	11
9	Завхан	40	11	29	-	20	17
10	Өвөрхангай	42	15	25	2	22	15
11	Өмнөговь	28	10	18	-	16	12
12	Сүхбаатар	24	11	13	-	15	10
13	Сэлэнгэ	39	7	30	2	30	20
14	Төв	49	6	34	9	7	4
15	Увс	33	15	18	-	14	9
16	Ховд	46	27	19	-	27	22
17	Хөвсгөл	45	19	24	2	29	25
18	Хэнтий	34	11	19	4	19	16
19	Дархан-Уул	45	39	6	-	23	20
20	Орхон	37	36	1	-	25	24
21	Говьсүмбэр	11	4	7	-	2	1
Аймгийн дүн		736	330	374	32	400	312
Нийслэл		672	672			252	204
Бусад (төмөр зам)		27	14	11	2	11	8

Судалгаанд хамрагдсан багш нарын хүйс, нас, ажилласан жилийг тоон үзүүлэлтээр 3-р хүснэгтэд үзүүлсэн болно. Хөгжмийн багш нарын 77% нь эмэгтэй. Насны хувьд 17-31 хувийн хооронд хэлбэлзэж байна (диаграмм 2). Хамгийн их 44 % хувь буюу 1-5 жил ажилласан залуу багш нар; 6-10 жил 23%; 11-15 жил 14%; 16-20 жил 6%; 21-28 жил 6%; 26 ба түүнээс дээш жил ажилласан багшийн тоо 7% эзэлсэн (диаграмм 3). Багш нар 6 дахь жилээс бүлгийн багш болох, ажлаа солих, гарах тохиолдол ажиглагдсан (50 орчим хувиар багассан). Энэ нь тухайн мэргэжлээр ажиллаж байгаа багш нарын ажиллах нөхцөл, сонирхол, нийгмийн асуудал зэрэг бусад шалтгаанаас болсон байх магадлалтай. Цэцэрлэгийн хөгжмийн багшаар ажиллаж байгаа багшийн 30-39 нас хамгийн их буюу 31 хувийг эзэлж байна. 1-5 жил ажилласан багшийн тоо 201 буюу 44 хувийг эзэлж байна (хүснэгт 3; диаграмм 2, 3). Зарим тохиолдолд хөгжмийн багш нар өөрийн хүүхдийг бага байхад цэцэрлэгт ажиллаж байгаад сургуульд ороход нь ЕБС-руу шилжих үзэгдэл ажиглагдсан. Энэ нь цэцэрлэгийн хөгжмийн багшийн хомсдолыг үүсгэх шалтгааны нэг болоод байна.

Хүснэгт 3

Хөгжмийн багш нарын хүйс, нас, ажилласан жил /тоон үзүүлэлтээр/

Судалгаанд хамрагдагсдын тоо	Хүйс		Нас					Ажилласан жил				
	Эм	Эр	20-29	30-39	40-49	50-с дээш	1-5	6-10	11-15	16-20	21-25	26-с дээш
455	349	106	109	142	126	78	201	103	63	29	28	31

Ажиллаж буй багш нарын мэргэжлийн зэрэг өөр байгаа нь 4-р хүснэгтээс ажиглагдаж байна. 2000 оноос өмнөх хөгжмийн багш мэргэжлээр төгсөгчдийн ихэнх хувь нь дипломын дээдтэй төгссөн.

Судалгаанд хамрагдсан 455 багшийн 265 буюу 65 хувь нь бакалаврын зэрэгтэй, 87 буюу 19 хувь нь дипломын дээд, 48 буюу 11 хувийг эзэлж буй багш нар ямар нэг мэргэжлийн их дээд сургууль, коллеж төгсөөгүй, 25 буюу 5 хувь нь магистрын зэрэгтэй. Иймээс ажлын байрны шаардлага, зах зээлийн эрэлт хэрэгцээний үндсэн дээр бакалаврын зэрэг олгох хөрвөх сургалтад хамрагдах нь зүйтэй (хүснэгт 4).

Хүснэгт 4

Хөгжмийн багш нарын мэргэжлийн зэрэг

Судалгаанд хамрагдагсан багшийн тоо	Мэргэжлийн зэрэг			
	Магистр	Бакалавр	Дипломын дээд	Бүрэн дунд сургууль, курс төгссөн
455	25	295	87	48
	5%	65%	19%	11%

Монгол улсын Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн гуравдугаар бүлгийн Цэцэрлэг, түүний зохион байгуулалт хэсгийн 8-р зүйлийн 16-р заалтад “Цэцэрлэгт бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэжлийн сургууль төгссөн хөгжмийн болон биеийн тамирын багш ажиллаж болно (Энэ хэсгийг 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар нэмсэн)” гэсэн заалт байдаг. Үүнээс харахад “ажиллаж болно” гэсэн заалт нь өөр мэргэжлийн хүн ажиллах эсвэл өөр боловсролын зэрэгтэй хүн ажиллах боломжтой гэсэн санааг агуулсан харагдаж байна.

Тухайн хуулийн тавдугаар бүлгийн Сургуулийн өмнөх боловсролын харилцаанд оролцогчид хэсгийн 12-р зүйлийн 12.1 заалтад “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллана” (Энэ хэсэгт 2016 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан) гэсэн заалтад СӨББ-д бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй хүн ажиллах шаардлагатай гэж хуульчилсан (Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив, 1995). Хэдий хуульд заасан ч хөгжмийн багшийн хэрэгцээ шаардлагаас хамааран судалгаанд хамрагдсан цэцэрлэгийн хөгжмийн багш мэргэжилтэй багш нарын 70 орчим хувь бакалавр түүнээс дээш зэрэгтэй, 30 орчим хувь нь мэргэжлийн зэрэггүй байна. Энэ нь хүүхдийн хөгжил, төлөвшил, сургалтын чанарт сөргөөр нөлөөлөх нөхцөл болно. Судалгаанд хамрагдсан хөгжмийн багшийн орон тоонд ажиллаж байгаа багш нарын 49 % нь мэргэжлийн, 51 % нь мэргэжлийн бус (хүснэгт 5; диаграмм 4) байна (судалгаанд Хөвсгөл, Булган, Орхон аймгийн багш нарын мэдээлэл ороогүй). Улсын хэмжээнд нийт 663-аас 455 хөгжмийн багш буюу 69% хамрагдсан нь судалгааны үр дүнг бодитой илэрхийлэх тоон үзүүлэлт юм.

Хүснэгт 5

Хөгжмийн багш нарын мэргэжлийн чиглэл

Судалгаанд хамрагдагсдын тоо	Мэргэжил				
	Хөгжмийн багш	Хөгжмийн бусад мэргэжлийн суурьтай	Багш суурьтай	Өөр мэргэжил эзэмшсэн	ЕБС төгссөн
455	224	71 (16%)	79 (17%)	66 (15%)	15 (3%)
Нийт	Мэргэжлийн (49 %)	Мэргэжлийн бус (51%)			

Судалгаанд хамрагдсан нийт 455 багш нарын 51 хувь буюу 231 нь *хөгжмийн багш бус* өөр мэргэжил эзэмшсэн. Хөгжмийн авьяас чадвартай, хүүхдийг хөгжүүлэх чин сэтгэлтэй олон багш нар байгааг үгүйсгэх аргагүй ч хөгжмийн сургалтын онол арга зүйн системтэй боловсрол эзэмшээгүйг илтгэж байна. Хөгжмийн урлагаар хүүхдийг хөгжүүлэхэд хүүхдээ таньж мэдэх, авьяас чадварын хөгжлийн түвшинг тодорхойлон, сургалт үйл ажиллагааг зохион байгуулах, төлөвлөх, хэрэгжүүлэх арга зүй, хөгжмийн гүйцэтгэлийн ур чадварыг зайлшгүй эзэмших шаардлагатай юм.

49 хувийг эзэлж буй *хөгжмийн багш мэргэжилтэй* багш нар ямар чиглэлээр суралцан төгссөн нь тодорхой бус байна (ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багш, цэцэрлэгийн хөгжмийн багш). Сургуулийн өмнөх боловсролын хөгжмийн багш, ерөнхий боловсролын сургуулийн хөгжмийн багшийн эзэмших арга зүй нь хүүхдийн насны онцлог, үйл ажиллагааны чиглэлээс хамааран өөр өөр байдаг.

Нийт судалгаанд хамрагдсан хөгжмийн багш нарын төгссөн сургууль, мэргэжлийн чиглэл өөр байгааг дээр дурдсан. Үүнд:

- *Хөгжмийн багш мэргэжилтэй:*
 - цэцэрлэгийн хөгжмийн багш
 - ЕБС хөгжмийн багш
 - багш урлагийн боловсрол г.м.
- *Хөгжмийн бусад мэргэжилтэй:*
 - хөгжмийн багш (хөгжмийн зэмсэг)
 - соёлын төвийн хөгжмийн багш
 - хөгжим судлаач
 - бүжгийн багш
 - найрал дууны багш
 - найрал хөгжмийн удирдаач
 - дуулах урлагийн багш
 - дуурийн дуучин
 - уртын дуучин
 - эстрад дуучин
 - үлээвэр хөгжимчин
 - хөгжимчин г.м.
- *Багш мэргэжилтэй:*
 - СӨБ багш
 - бага ангийн багш
 - физикийн багш
 - хятад, франц, англи хэлний багш
 - мэдээлэл зүйн багш г.м.
 - хүмүүжүүлэгч багш
 - монгол хэл уран зохиолын багш
 - биеийн тамирын багш
 - сурган сэтгэл судлалын багш г.м.
- *Өөр мэргэжилтэй:*
 - соёлын ажилтан, соёл судлаач
 - соёл гэгээрлийн ажилтан
 - орон судлаач
 - түүх музейн мэргэжилтэн
 - үйлдвэрийн болон бусад чиглэлийн инженер
 - нягтлан бодогч
 - бизнесийн удирдлага
 - машинист
 - товар судлаач
 - хүний нөөцийн мэргэжилтэн
 - орчуулагч
 - урлагийн менежер
 - бага эмч г.м.
- *Бусад:*
 - курс болон МСҮТ
 - ЕБС төгссөн багш нар тус тус ажиллаж байна.

Дүгнэлт

Монгол улсын хэмжээнд цэцэрлэгийн хөгжмийн багшийн хүрэлцээ дутмаг байгаа нь олон шалтгаантай. Мэргэжлийн яам, МУБИС-ийн зүгээс бодлогоор хөгжмийн багш нарын ур чадвар, арга зүйг дээшлүүлэх, мэргэжлийн зэрэг олгох сургалтыг зохион байгуулахыг дэмжих;

цэцэрлэгийн багш бэлтгэх их дээд сургуулийн сургалтын хэрэглэгдэхүүн, хөгжмийн зэмсэг, материаллаг орчныг бүрдүүлэх, их дээд сургуулийн ганцаарчилсан хөгжмийн сургалтын зардлын асуудлыг шийдэх; цэцэрлэгийн хөгжмийн багшийн нийгмийн асуудал, ажиллах нөхцөлийг сайжруулах, илүү цаг, бүлгийн тоо, хүүхдийн тоог харгалздаг байх; их дээд сургуульд мэргэжлээ дээшлүүлэн суралцах нөхцөлийг бүрдүүлэх, дэмжих шаардлагатай байна.

Дараах асуудлуудыг шийдэх нь Монгол улсад цэцэрлэгийн хөгжмийн багшийн эрэлт хэрэгцээг хангахад тодорхой хувь нэмэр оруулна:

Цэцэрлэгийн бүлгийн тоо, нэг ангид хамрагдах хүүхдийн тооны ачааллыг харгалзан сургалт үйл ажиллагааг төлөвлөх, багшийн ажлын хөлсийг тооцдог болох. Багш 16 бүлэгтэй цэцэрлэг, 4 бүлэгтэй цэцэрлэгт ажиллах, 25 хүүхэдтэй 60 хүүхэдтэй ангид ажиллахад цалингийн хувьд ямар ч ялгаа байхгүй. Иймээс цэцэрлэгийн стандарт нормыг шинэчлэн сайжруулах, хүүхдийн тоо, багшийн ажлын хөлс, цаг тооцох аргачлалыг тодорхой болгох. Багшид хөгжмийн дугуйлангийн цагийг тооцдог болох.

Ажиллаж буй мэргэжлийн бус хөгжмийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх хөрвөх сургалтад хамруулах. Сургалтад хамрагдах хүсэлтэй багш нарын эдийн засгийн нөхцөлийг харгалзан тодорхой зохицуулалт хийх, дэмжлэг үзүүлэх. Ажиллаж буй багш нар сургуульд элсэхэд ЕЭШ-ын асуудлыг журмаар зохицуулах. Туршлагатай багш нарыг тодорхой шалгуурын дагуу цаашид тогтвортой ажиллах нөхцөлтэйгөөр төрийн сангийн зээлд хамруулах, цалинтай чөлөө олгох, нийгмийн даатгалыг суралцах хугацаанд төлөх, цалин хөлс, ажлын ачаалал, ажиллах нөхцөлийг сайжруулах зэрэг дэмжлэг тусалцаа үзүүлэх.

Цэцэрлэгийн хөгжмийн багш бэлтгэх их дээд сургуулийн сургалт үйл ажиллагааг МУБИС, БСШУСЯ-ны зүгээс дэмжих, чанарыг сайжруулах. Сургалтын төлөвлөгөөг хувилбартайгаар боловсруулах, суралцах хугацааг уян хатан болгох. Ганцаарчилсан мэргэжлийн хөгжмийн хичээлийн өртөг зардал өндөр тул тухайн хичээлийн зохион байгуулалт, багшид тооцох кредит, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын асуудлыг шийдэн тодорхой болгох.

Дээрх асуудлыг шат дараалан шийдвэрлэн багш нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нь бага насны хүүхдийн хөгжилд, монголын ирээдүй, улс орны хөгжилд чухал хувь нэмэр оруулах боломж бүрдэнэ.

Ном зүй

- Ариунзул, Ө., Эрдэнэжаргал, Ц. (2016). *Цэцэрлэгийн хөгжмийн багш нарт тулгарч буй зарим асуудал*. “Сургуулийн өмнөх болон бага боловсролын асуудал шийдэл” олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл. Улаанбаатар
- Пүрэвсүрэн, Д. (2007). *Монголын хөгжмийн боловсролын уламжлал шинэчлэл*. Улаанбаатар: Сод пресс.
- Цогтгэрэл, Ш., Баттогоо, Ш. (2013). *Дуу хөгжмийн багш нарын дундариггүй түүх.....* Улаанбаатар: ВСИ
- Эрдэнэчимэг, С. (2012). *Сургуулийн өмнөх боловсролын сургууль-багачуудыг дээдэлсэн эрдмийн өргөө*. Улаанбаатар: Урлах эрдэм
- Сургуулийн өмнөх боловсролын 2018-2019 статистик мэдээ. (2019). Боловсрол соёл шинжлэх ухаан, спортын яамны веб сайт. <https://mecss.gov.mn/news/1386/>
- Сургуулийн өмнөх боловсролын тухай. (2008). УИХ. Монгол улсын хууль. <https://www.legalinfo.mn/law/details/462>
- Хүүхдийн цэцэрлэгийн захиргаа үйлчилгээний ажилтны орон тооны үлгэрчилсэн норматив. Сангийн сайдын 1995 оны 227, 199 дүгээр хамтарсан тушаалын хоёрдугаар хавсралт. Шинжлэх Ухаан, Боловсролын Яам (1995). <https://www.legalinfo.mn/annex/details/8382?lawid=13301>

Mongolian professional music teacher's needs and current situation

Batsaikhan.D*, Erdenetuya.Ts

Department of art, School of preschool education,
Mongolian State University of Education,

Abstract

This article focuses on the needs of kindergarten music teachers in Mongolia, the professional orientation and skills of teachers, and some of the current issues. According to the statistics of preschool education for 2018-2019 conducted by the Ministry of Education, Science and Sport, there are 663 music teachers in 1435 kindergartens. Of particular concern is the fact that more than 50% of kindergarten lacks professional music teachers nationwide and the teachers working there are unprofessional. From this number, it is uncertain whether theoretical musical training or activity is being conducted. This raises questions on topics relating to this matter such as the college and university courses that prepare music teachers, the graduation and the availability of music teachers, the reasons why they may not work as teachers, the professional orientation of the teachers that are working in, and the status of working conditions and some social issues. Statistics show that there is a shortage of music teachers and a lack of professionalism. Therefore, there is a need to find ways to solve the problem and opportunities for professional development of a music teacher. This article has included ways to increase the reach of a music teacher and suggestions of ways to solve the problem.

Keywords

Kindergarten music teacher, teachers competence, music teacher preparation, early childhood music education.

* Corresponding author: batsaikhan@msue.edu.mn